



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/08/НА-СА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 11327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ё.Лхагвадулам Утас: 11325093 Цахим хаяг: lkhagvadulamyo@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Тэгшлхам Утас: 11325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Ариунзаяа Утас: 11325093 Цахим хаяг: ariunzayaba@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.25 № 723
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН
СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
Н.АЛТАНШАГАЙ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус дүүргийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно

Аудитын гол асуудал

Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг нь сайн засаглалыг хөгжүүлэх, цахим засаглалыг нэвтрүүлэх, дотоод удирдлага хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор MNS 180 9001:2015 стандартыг хороодод нэвтрүүлж эхлээд байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дүүргийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		15,869,449.0	32,237,179.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	13,569,242.6	24,824,374.9
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0	0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	720,694.4	662,904.8
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	185,410.5	3,933,302.6
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,394,101.6	2,816,596.7
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0	0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		63,496,815.0	65,086,148.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0	0
37100	Урт хугацаат хадгаламж		0	0
37200	Үнэт цаас		0	0
37300	Урт хугацаат зээл		0	0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	63,496,815.0	65,086,148.6
39100	Газар		0	0
39200	Биет хөрөнгө		57,138,035.5	58,733,401.0
39300	Биет бус хөрөнгө	13	6,358,779.5	6,352,747.6
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		79,366,264.1	97,323,327.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,967,149.6	10,135,301.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,258,436.7	7,781,353.8
41100	Богино хугацаат үнэт цаас		0	0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0	0
41300	Өглөг	17а, 17б	3,330,147.3	4,422,084.1
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,928,289.4	3,359,269.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		708,712.9	2,353,947.5
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0	0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	708,712.9	2,353,947.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		73,399,114.5	87,188,026.3
51	Засгийн газрын хувь оролцоо		73,399,114.5	87,188,026.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		21,597,136.9	21,597,136.9
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		595,447.4	595,447.4
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0	0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		0	0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0	0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		0	0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		209,000.0	8,824,146.4
51200	Хуримтлагдсан үр дүн		32,666,468.4	39,940,853.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		18,331,061.9	16,230,442.1
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0	0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		79,366,264.1	97,323,327.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		87,883,791.6	133,494,831.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО		67,518,511.8	95,621,108.0
110	Орлогын албан татвар		51,353,136.0	75,715,997.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		51,353,136.0	75,715,997.4
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0	0
113	Хөрөнгийн албан татвар		3,116,906.6	5,063,050.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж		13,048,469.2	14,842,059.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	14,335,021.6	12,015,990.7
120	Нийтлэг татварын бус орлого		11,544,032.6	7,643,918.2
121	Хөрөнгийн орлого		0	0
122	Тусламжийн орлого		0	0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		2,790,989.0	4,372,072.5
124	Зээлийн орлого		0	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,030,258.2	25,857,733.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	64,838,132.3	115,541,330.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		64,838,132.3	115,541,330.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		57,958,174.2	103,503,378.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		13,261,997.9	13,895,474.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,757,339.0	1,850,695.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,040,028.7	12,008,074.5
2104	Хангамж, бараа материалын зардал		2,498,058.4	4,312,664.7
2105	Нормативт зардал		27,177.9	32,984.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,422,306.6	5,727,276.4
2107	Томилот, зочны зардал		9,128.2	328,057.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,756,195.9	24,233,670.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		9,185,941.6	41,114,479.6
211	ХҮҮ		0	0
212	ТАТААС		0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,879,958.1	12,037,952.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		23,045,659.3	17,953,501.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		197,948,743.7	12,779,736.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-174,903,084.4	5,173,765.5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,543,396.9	0	248,543,396.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-777,745.4	0	-777,745.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,765,651.5	0	247,765,651.5
7	Өмчид гарсан өөрчлөлт	536,547.4	0	536,547.4
9	Тайлант үеийн үр дүн	-174,903,084.4	0	-174,903,084.4
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,399,114.5	0	73,399,114.5
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	73,399,114.5	0	73,399,114.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,100,619.8	0	2,100,619.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,499,734.2	0	75,499,734.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,100,619.8	0	-2,100,619.8
17	Өмчид гарсан өөрчилөлт	8,615,146.4	0	8,615,146.4
19	Тайлант үеийн үр дүн	5,173,765.5	0	5,173,765.5
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	87,188,026.3	0	87,188,026.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		79,715,144.2	123,656,397.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		67,518,511.8	95,621,108.0
110	Орлогын албан татвар		51,353,136.0	75,715,997.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		51,353,136.0	75,715,997.4
113	Хөрөнгийн албан татвар		3,116,906.6	5,063,050.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж		13,048,469.2	14,842,059.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		3,726,545.4	4,203,859.7
1181	Газрын төлбөр		9,317,414.8	10,632,542.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		4,509.0	5,658.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		6,006,952.8	10,244,022.6
120	Нийтлэг татварын бус орлого		3,215,963.8	5,871,950.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		2,790,989.0	4,372,072.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,189,679.6	17,791,266.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		65,488,226.0	102,336,186.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		65,488,226.0	102,336,186.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		55,486,545.8	87,200,226.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		17,805,738.6	19,092,515.1

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,644,064.6	3,747,942.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,561,596.1	12,527,037.0
2104	Хангамж, бараа материалын зардал		11,168,063.3	17,229,253.8
2105	Нормативт зардал		88,014.1	47,011.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,297,955.2	5,352,807.4
2107	Томилолт, зочны зардал		9,128.2	338,178.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,196,617.2	7,650,376.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		5,715,368.4	21,215,104.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		10,001,680.2	15,135,960.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		14,226,918.2	21,320,210.7
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		27.8	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		7,987,588.1	10,065,078.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		7,987,588.1	10,065,078.3
2200	Дотоод эх үүсвэрээр		7,987,588.1	10,065,078.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-7,987,560.4	-10,065,078.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-10,000.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		10,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		6,229,357.8	11,255,132.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		7,339,884.8	13,569,242.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		13,569,242.6	24,824,374.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,201,220,100.00	93,383,709,612.42	15,817,510,487.58	85.5
УРСГАЛ ЗАРДАЛ	92,942,811,100.00	84,732,770,364.82	8,210,040,735.18	91.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,512,783,600.00	70,363,436,622.32	6,149,346,977.68	92.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,150,725,700.00	13,896,226,634.60	254,499,065.40	98.2
Үндсэн цалин	6,011,432,700.00	6,067,636,414.91	-56,203,714.91	100.9
Нэмэгдэл	1,486,536,800.00	1,465,333,435.09	21,203,364.91	98.6
Унаа хоолны хөнгөлөлт	1,883,482,400.00	1,780,627,423.00	102,854,977.00	94.5
Урамшуулал	747,990,200.00	601,566,904.92	146,423,295.08	80.4
Гэрээт ажлын хөлс	4,021,283,600.00	3,981,062,456.68	40,221,143.32	99.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,775,259,600.00	1,729,058,292.03	46,201,307.97	97.4

Тэтгэврийн даатгал	1,216,665,100.00	1,192,149,388.15	24,515,711.85	98.0
Тэтгэмжийн даатгал	141,004,900.00	137,667,520.78	3,337,379.22	97.6
ҮОМШӨ-ний даатгал	107,978,900.00	104,845,255.32	3,133,644.68	97.1
Ажилгүйдлийн даатгал	28,301,000.00	25,156,726.77	3,144,273.23	88.9
Эрүүл мэндийн даатгал	281,309,700.00	269,239,401.01	12,070,298.99	95.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,844,490,600.00	11,998,494,272.92	1,845,996,327.08	86.7
Гэрэл, цахилгаан	4,257,545,800.00	3,446,029,066.42	811,516,733.58	80.9
Түлш, халаалт	6,272,546,200.00	5,720,137,317.45	552,408,882.55	91.2
Цэвэр, бохир ус	2,344,718,400.00	2,081,460,629.05	263,257,770.95	88.8
Байрны түрээс	969,680,200.00	750,867,260.00	218,812,940.00	77.4
Хангамж, бараа материалын зардал	12,404,982,400.00	12,203,073,176.07	201,909,223.93	98.4
Бичиг хэрэг	114,070,200.00	104,054,549.00	10,015,651.00	91.2
Тээвэр, шатахуун	75,085,200.00	60,503,110.00	14,582,090.00	80.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	97,683,700.00	88,037,609.07	9,646,090.93	90.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,505,640,000.00	11,504,631,500.00	1,008,500.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	612,503,300.00	445,846,408.00	166,656,892.00	72.8
Нормативт зардал	58,314,600.00	47,670,950.00	10,643,650.00	81.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,730,600.00	4,730,600.00	0.00	100.0
Хоол, хүнс	21,850,000.00	17,506,200.00	4,343,800.00	80.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,734,000.00	25,434,150.00	6,299,850.00	80.1
Эд хогшил, урсгал засварын зардал	6,254,810,300.00	6,175,671,507.25	79,138,792.75	98.7
Багаж, техник, хэрэгсэл	364,887,100.00	331,986,005.50	32,901,094.50	91.0
Тавилга	124,499,000.00	110,534,429.50	13,964,570.50	88.8
Урсгал засвар	5,765,424,200.00	5,733,151,072.25	32,273,127.75	99.4
Томилолт, зочны зардал	446,853,100.00	338,178,691.20	108,674,408.80	75.7
Гадаад албан томилолт	359,158,300.00	290,882,100.20	68,276,199.80	81.0
Дотоод албан томилолт	37,694,800.00	13,852,000.00	23,842,800.00	36.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	50,000,000.00	33,444,591.00	16,555,409.00	66.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,109,945,400.00	5,655,876,994.00	454,068,406.00	92.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,066,465,600.00	5,634,183,945.00	432,281,655.00	92.9
Даатгалын үйлчилгээ	1,799,000.00	0	1,799,000.00	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	1,154,900.00	1,120,664.00	34,236.00	97.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	265,000.00	190,000.00	75,000.00	71.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,489,800.00	10,889,500.00	2,600,300.00	80.7
Газрын төлбөр	26,771,100.00	9,492,885.00	17,278,215.00	35.5
Бараа үйлчилгээний бусад зардал	21,467,401,900.00	18,319,186,104.25	3,148,215,795.75	85.3
Бараа үйлчилгээний бусад зардал	21,356,346,900.00	18,235,447,444.25	3,120,899,455.75	85.4

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,055,000.00	83,738,660.00	27,316,340.00	75.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,430,027,500.00	14,369,333,742.50	2,060,693,757.50	87.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,596,970,200.00	13,692,086,520.50	1,904,883,679.50	87.8
Засгийн газрын дотоод шилжүүлэг	15,596,970,200.00	13,692,086,520.50	1,904,883,679.50	87.8
Бусад урсгал шилжүүлэг	833,057,300.00	677,247,222.00	155,810,078.00	81.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	77,000,000.00	73,915,000.00	3,085,000.00	96.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,000,000.00	42,996,500.00	3,500.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	192,747,300.00	145,362,995.00	47,384,305.00	75.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,310,000.00	414,972,727.00	105,337,273.00	79.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,258,409,000.00	8,650,939,247.60	7,607,469,752.40	53.2
Барилга байгууламж	1,705,400,000.00	1,053,832,208.00	651,567,792.00	61.8
Их засвар	1,326,205,100.00	916,343,332.00	409,861,768.00	69.1
Тоног төхөөрөмж	601,500,000.00	233,829,560.00	367,670,440.00	38.9
Бусад хөрөнгө	12,625,303,900.00	6,446,934,147.60	6,178,369,752.40	51.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	109,201,220,100.00	94,586,156,750.17	14,615,063,349.83	86.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,439,386,900.00	4,372,072,470.00	67,314,430.00	98.5
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,439,386,900.00	4,372,072,470.00	67,314,430.00	98.5
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	92,073,819,800.00	89,886,975,608.33	2,186,844,191.67	97.6
Орон нутгийн төсвөөс	92,073,819,800.00	89,886,975,608.33	2,186,844,191.67	97.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,688,013,400.00	327,108,671.84	12,360,904,728.16	2.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	337,500,000.00	326,996,183.59	10,503,816.41	96.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	112,488.25	-112,488.25	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	12,350,513,400.00	0	12,350,513,400.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	634,734,666.00	-634,734,666.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,837,181,803.75	-1,837,181,803.75	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,917.00	1,905.00	12.00	99.4
БАЙГУУЛЛАГЫН ТОО	9	9	0.00	100.0
Төсвийн байгууллага	9	9	0.00	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	954	948	6.00	99.4
Удирдах ажилтан	14	15	-1.00	107.1
Гүйцэтгэх ажилтан	309	304	5.00	98.4
Үйлчлэх ажилтан	156	154	2.00	98.7
Гэрээт ажилтан	475	475	0.00	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	954	948	6.00	99.4

Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	188	189	-1.00	100.5
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	6	6	0.00	100.0
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	16	16	0.00	100.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	3	1	2.00	33.3
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	220	215	5.00	97.7
Гэрээт ажилтан	475	475	0.00	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	46	46	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,678,519,373.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,678,519,373.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,449,842,588.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,107,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,107,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,251,735,328.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,251,735,328.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,228,676,785.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	826,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	820,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	402,676,785.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	402,676,785.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,678,519,373.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,678,519,373.20
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	111,739,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,013,711,194.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	553,068,779.20
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2,249,427.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

3.1 Залруулсан алдаа:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд авлага, өглөгийн эхний үлдэгдлийг 137,345.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.Энэ нь УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт болон санхүүгийн тайлангийн “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого (*илүү*), зардал (*дутуу*) 26,361.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан (*УССТ-23,222.0 мянга, ХААА-3,139.0 мянга*) УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг) болон санхүүгийн тайлангийн “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Арилжааны банкны дансны үлдэгдэл 112.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан. (*ИТХ*) Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Санхүүгийн тайлангаарх болон татварын тайлангийн өглөгийн үлдэгдэл 8,762.9 мянган төгрөгөөр зөрүүтэй (*СХД Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ*) Энэ нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн хэмжилт, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
- Ажилчдын цалингаас суутгасан зарим суутгал 35,490.7 мянган төгрөгийг холбогдох байгууллага, хувь хүнд шилжүүлэхдээ дансны бичилтийг алдаатай хийсэн (*ЗДТГ*) Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 57,666.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэн орлогод авахдаа бусад орлогоор бүртгээгүй (*Жаргалант тосгоны Соёлын ордон*) УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг) болон санхүүгийн тайлангийн “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үндсэн хөрөнгийн дансанд 1,663,000.0 мянган төгрөгийн орлого авахдаа эздийн өмчийн бусад хэсэг дансыг нэмэгдүүлж бүртгэсэн (*СХД Тохижилт,*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ) . Энэ нь НББОУС 20 "Засгийн газрын буцалтгүй тусламж", иж бүрэн байх зарчмыг баримталж ажиллах, санхүүгийн тайлангийн хэмжилт, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

- Гүйлгээ баланс болон үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 294.3 мянган төгрөгөөр зөрүүтэй. (СХД Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ) Энэ нь НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн хэмжилт, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
- Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын ангиллыг 25,087.1 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн (Орон нутгийн хөрөнгө оруулалт)) Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн "ангилал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Олгохоор тооцсон цалин, суутгасан суутгал 134,360.2 мянган төгрөгийн дансны бичилт алдаатай (Жаргалант тосгоны ЗАА-97,388.2 мянга, Амралт цогцолборын газар-36,972.0 мянга) Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 10,844.1 мянган төгрөгийн бараа материалыг ангилал зөрүүтэй бүртгэсэн (Амралт цогцолборын газар) УСНББОУС-12 Бараа материал болон тайлангийн хэмжилт болон санхүүгийн тайлангийн "ангилал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Дүүргийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 148,600.0 мянган төгрөгийн дээврийн засварыг барилгын өртөгт нэмж бүртгээгүй (Амралт цогцолборын газар) НББОУС 20 "Засгийн газрын буцалтгүй тусламж", иж бүрэн байх зарчмыг баримталж ажиллах болон санхүүгийн тайлангийн "оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Санхүүгийн тайланд 81.2 мянган төгрөгийн авлага дутуу тайлагнасан (ЖДҮДМСТ) Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн "оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд 1,423.1 мянган төгрөгийн цалин, ажил олгогчийн шимтгэлийн зардлыг зөрүүтэй тайлагнасан.(ЖДҮДМСТ) Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 251,555.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 6,289.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 245,265.9 мянган төгрөгийн 23 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар

ОНХС-ийн хөрөнгөөр болон дүүргийн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хуульд заасан эрэмбийг баримталсан эсэх нь тодорхойгүй, нотлох баримтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйл 27.6. "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дараах эрэмбийг баримтална:" 27.6.1. "шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ;" 27.6.2. "их засвар, засвар арчлалтын төсөл, арга хэмжээ;" 27.6.3. шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ." заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан эрэмбийг баримталж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

3.2 Төлбөрийн акт

- Албан хэрэгцээнд дуудлагын авто машин ашиглахдаа тогтоосон нормыг 864.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн Энэ нь Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны 204 дүгээр тогтоолын 8 " энэ тогтоолын хавсралтад заасан суудлын автомашиныг өдрийн 60км, дуудлага үйлчилгээний автомашиныг өдрийн 40 км-ээс хэтрэхгүйгээр ашиглах байхаар тогтоосугай" заалтыг зөрчиж байна. (ИТХ)
- Зохиогчийн хяналт магадалшгүй ажлын зардал 5,425.4 мянган төгрөгийг барьцаа дэнчингийн өглөгөөр бүртгэгдсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7. "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" заалтыг зөрчиж байна. (дүүргийн орон нутгийн хөрөнгө оруулалт)

3.3 Албан шаардлага

- Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдээдэнэ.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. (ХААА)

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудлын талаар:

Илрүүлэлт: Нийслэлийн 16 сургуульд ашиглагдаж байгаа хүүхдийн автобус тус байгууллагад бүртгэлтэй байгаа нь тус байгууллагын хөрөнгийг нэмэгдүүлж, зардлыг өсгөх үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна." заалтыг хэрэгжүүлээгүй байна (ЗДТГ)

Өгсөн зөвлөмж: Бусад байгууллагад (16 сургуульд) ашиглагдаж байгаа тухайн байгууллагын дансанд бүртгэлтэй 16 ширхэг автобусыг ашиглагч байгууллагад шилжүүлэх хүсэлтийг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өглөө

Илрүүлэлт: Газрын хэмжээг 225 м2-аар буюу 2,981.2 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байгаа нь тус байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдлийг алдаатай илэрхийлэх үр дагаварт хүргэж байна Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1."Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:" 5.1.3"жинхэнэ хэрэгжилтийн;" 5.1.4."үнэн зөв байх;" Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" 2 дугаар зүйлийн 2.1.4 "Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх". заалтуудыг зөрчсөн байна.(ЖДҮДМСТ)

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд газрын хэмжээг үнэн зөвөөр нь бүргэж, тайлагнаж байх, зөрчлийг арилгах.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн шинж чанартай 15,226.7 мянган төгрөгийн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн нь эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэл алдаатай илэрхийлэгдэх үр дагаварт хүргэж байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн зааврыг тус тус мөрдөөгүй байна. (Жаргалант тосгоны Соёлын ордон-13,516.7 мянга, СХД Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ 1,710.0 мянга)

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх;

Илрүүлэлт: Хуримтлагдсан элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 4 нэр төрлийн 51 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа нь хөрөнгийн бодит үлдэгдэл алдаатай илэрхийлэгдэх үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.22" илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;"заалтыг хэрэгжүүлээгүй байна.(СХД Тохижилт , цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ)

Өгсөн зөвлөмж: Хуримлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдээс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлүүлэн бүртгэлд тусгах, ашиглагдах боломжгүй хөрөнгийг актлуулах саналыг холбогдох байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх;

2. Зардлын данстай холбоотой асуудлын талаар:

Илрүүлэлт: Албан хэрэгцээнд дуудлагын авто машин хэрэглэхдээ илүү цагаар ажиллуулж 16,004.4 мянган төгрөгийн зардал гаргасан нь төсвийг үр ашиггүй зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих хяналт сулрах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" заалтыг хэрэгжүүлээгүй байна. (ЗДТГ-6,834.0 мянга, ИТХ-9,170.4 мянга)

Өгсөн зөвлөмж: Албан тушаалтан ажлын хэрэгцээнд дуудлагаар ашиглаж байгаа автомашиныг илүү цагаар ажиллуулахгүй байж төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудлын талаар:

Илрүүлэлт: Худалдан авалт цахим төлбөрийн и-баримтгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 10,113.6 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүртгэсэн нь анхан шатны баримтын бүрдэлд бүртгэлээр тавих хяналт сулрах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудтай нийцээгүй байна. (СХД Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ-6,433.6 мянга, ХААА-3,680.0 мянга)

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4. Өглөгийн данстай холбоотой асуудлын талаар:

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангаарх 178,543.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, барагдуулаагүй нь санхүүгийн тайлангийн

өглөг барагдахгүй байх, эзэн холбогдогч тодорхойгүй болох үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтыг хэрэгжүүлээгүй байна. (ОНХС-106,790.3 мянга, орон нутгийн хөрөнгө оруулалт-66,505.5 мянга, ЗДТГ-600.0 мянга, СХД тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ-4,647.4 мянга)

Өгсөн зөвлөмж: Өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулж байх, барагдуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Илрүүлэлт ХХОАТ-ын дутуу төлөлт 1,977.6 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй байгаа нь санхүүгийн тайланд өр төлбөр дутуу тайлагнагдах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.4.3 "бүх өр төлбөр;" заалтыг хэрэгжүүлээгүй байна. (Жаргалант тосгоны ЗАА)

Өгсөн зөвлөмж: ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

5. Бараа материалын данстай холбоотой асуудлын талаар:

Илрүүлэлт Бараа материалын үлдэгдэлд хүчингүй болсон, ашиглагдахгүй 8,706.7 мянган төгрөгийн үнэт цаас бүртгэлтэй байгаа нь ашиглалтын шаардлага хангасан бараа материалын үлдэгдэл алдаатай илэрхийлэгдэх үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1. "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно." заалтыг хэрэгжүүлээгүй байна. (ЗДТГ)

Өгсөн зөвлөмж: Хүчингүй болон ашиглагдахгүй болсон үнэт цаасыг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлж, данс бүртгэлээс хасах;

Илрүүлэлт: 2,900.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг орлого аваагүй шууд зардлаар бүртгэсэн нь хөрөнгийг бүртгэлд дутуу тусгах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын 1 дүгээр хавсралтын "Бараа материалын бүртгэл"-ийг зөрчсөн байна. (Жаргалант тосгоны Соёлын ордон-900.0 мянга, ЖДҮДМСТ-2,000.0 мянга)

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг анхан шатны баримтыг үндэслэн орлогод авч шаардах хуудсаар зарцуулалт хийж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт: Жолоочийн замын тооцооны хуудсаар зарцуулсан шатахуун, бараа материалын тайлангийн зарцуулалтаас 852.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.(ХААА)

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримыг үндэслэн гүйлгээг нягтлан болох бүртгэлд үнэн зөвөөр тусгаж байх.

6. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар:

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалин хөлсийг 5,812.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь ажилчдын цалин, түүнээс суутгуулсан нийгмийн даатгалын шимтгэл алдаатай илэрхийлэгдэх үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг хэрэгжүүлээгүй байна. (ЗДТГ-5,086.1 мянга, ИТХ-726.8 мянга)

Өгсөн зөвлөмж: Ажилчдын цалин хөлсийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд үнэн зөв тайлагнаж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт: Цалингаас суутгасан болон татварын тайлангийн ногдуулсан татвар 1,527.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь татварын хөнгөлөлтийг буруу тооцон тайлагнах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн байна. (ИТХ)

Өгсөн зөвлөмж: Жилийн эцэст хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасны дагуу албан татвар ногдуулах жилийн орлого болон татварын хөнгөлөлтийн хэмжээг албан хаагч нэг бүрээр үнэн зөв тооцож, тайлагнаж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

7. Авлагын данстай холбоотой асуудлын талаар:

Илрүүлэлт: ХХОАТ-ын 620.0 мянган төгрөгийн илүү төлөлтийг санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй нь санхүүгийн тайланд авлага дутуу илэрхийлэгдэх үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг хэрэгжүүлээгүй байна. (ЗДТГ)

Өгсөн зөвлөмж: Татварын тайлангийн илүү төлөлтийг 2024 онд суутган тооцож, авлагыг барагдуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Байгууллагын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй байна. Энэ нь Стандарт, хэмжилзүйн газрын даргын баталсан "MNS 4410-1-2002, Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг, 1-р хэсэг : Ерөнхий шаардлага стандартын 5.4.9 дэх заалт "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо,

үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна” заалтыг хэрэгжүүлээгүй байна. (ЗДТГ, ИТХ, Захиалагчийн алба ОНӨААТҮГ)

Шийдвэрлэсэн нь: Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр сольж ашиглах хүсэлтийг холбогдох байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх зөвлөмж өглөө.

Төсвийн хөрөнгөөр 252,555.1 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ цахим дэлгүүрээс аваагүй байна.(ЗДТГ) Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7.”аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх;” 14 дүгээр 14.1.”Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ,”14.4.”Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн, цахим дэлгүүрээс худалдан авалт хийх, зөрчлийг давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд гарсан чадавхжуулах зардлыг холбогдох захирамж, мөнгөн хөрөнгийн журнал, гэрээ, хэлцэл, анхан шатны баримт руу хөөн шалгахад УИХ-д суудалтай намд олгох төрийн санхүүгийн дэмжлэгт орон нутгийн төсвөөс нийт 42 төлөөлөгчийн 21,000.0 мянган төгрөгийг олгосон. (ИТХ) Энэ нь Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.”Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна.” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: УИХ-д суудалтай намуудад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгохгүй байх зөвлөмж өглөө.

Иргэдийн хурлын төлөөлөгчдийн гадаад томилолтын зардалд 60,938.0 мянган төгрөгийг зарцуулсан. (ИТХ) Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 ”энгийн хялбар, чанга хатуу байх”; 4.1.3 “үр ашигтай байх”; 12 дугаар зүйлийн 12.1”Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно.”; 12.1.4 ”хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын 3.2.6. ”гадаад улсын болон дотоодын туршлага судлах сургалт”;заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлээ.

3.6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Тохижилт,цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12,615.0 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, 312,839.9 мянган төгрөгийн зарлагын 15 гүйлгээг мэдээлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;*"; 6 дугаар зүйлийн 6.4."*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ;*", 6.4.5."*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,*" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд гүйлгээг мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага өгсөн.

3.7 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант хугацаанд Засгийн газрын тогтоосон босго үнээс илүү өртөг бүхий 346,854.2 мянган төгрөгийн материалыг худалдан авахдаа үнийн харьцуулалт хийгээгүй, тендер зарлаагүй байна. (СХД Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ ОНӨААТҮГ) Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйл Тендер шалгаруулалтын зохион байгуулалт 10.3."*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллах журмыг баримтлах, зөрчлийг арилгах албан шаардлага өглөө.

Тайлант онд үнийн харьцуулалт хийлгүй 47,069.9 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн (*Жаргалант тосгоны Соёлын ордон*)

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллах журмыг баримтлах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СХД-ийн Санхүүгийн нэгтгэсэн тайланд авлага, өглөгийн эхний үлдэгдлийг илүү тайлагнасан	1	137,344.5			1	137,344.5	1	137,344.5				
Нэгтгэсэн тайлангийн дүн	1	137,344.5			1	137,344.5	1	137,344.5				
СХД-ийн Засаг даргын Тамгын газар	1	35,490.7			1	35,490.7	1	35,490.7				
СХД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	112.5	1	112.5			1	112.5	-	-	-	-
СХД-ийн Усан спорт сургалтын төв	1	23,222.0			1	23,222.0	1	23,222.0	-	-	-	-
СХД-ийн Худалдан авах ажиллагааны алба	1	3,139.0			1	3,139.0	1	3,139.0				
СХД-ийн Жаргалант тосгоны Соёлын ордон	1	57,666.3			1	57,666.3	1	57,666.3				
СХД-ийн орон нутгийн хөрөнгө оруулалт	1	25,087.1			1	25,087.1	1	25,087.1				
СХД-ийн Жаргалант тосгоны Захирагчийн ажлын алба	1	97,388.2			1	97,388.2	1	97,388.2				
СХД-ийн ЖДҮДМСТ	2	1,504.3			2	1,504.3	2	1,504.3				
Орон нутгийн байгууллагын дүн	9	243,610.1	1	112.5	9	243,497.6	9	243,610.1				
СХД-ийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ	3	1,672,057.2			3	1,672,057.2	3	1,672,057.2	-	-	-	-
СХД-ийн Амралт цогцолборын газар	3	196,416.1			3	196,416.1	3	196,416.1				
ОНӨААН-ийн дүн	6	1,868,473.3	0	0	6	1,868,473.3	6	1,868,473.3	0	0	0	0
Нийт дүн	16	2,249,427.9	1	112.5	15	2,249,316.4	16	2,249,427.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ОНХС-ийн хөрөнгөөр болон дүүргийн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хуульд заасан эрэмбийг баримталсан эсэх нь тодорхойгүй, нотлох баримтгүй байна	1						1					
Нэгтгэсэн тайлангийн дүн	1						1					
СХД-ийн Засаг даргын Тамгын газар	6	21,846.8					6	21,846.8	-	-	-	-
СХД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	12,288.9	1	864.3			3	11,424.6	-	-	-	-
СХД-ийн Орон нутгийн хөрөнгө оруулалт	2	71,930.9	1	5,425.4			1	66,505.5	-	-	-	-
СХД-ийн Худалдан авах ажиллагааны алба	3	4,532.2			1		2	4,532.2	-	-	-	-
СХД-ийн Жаргалант тосгоны Соёлын ордон	2	14,416.7					2	14,416.7	-	-	-	-
СХД-ийн ЖДҮДМСТ	2	4,981.2					2	4,981.2	-	-	-	-
СХД-ийн ОНХС	1	106,790.3					1	106,790.3	-	-	-	-
СХД-ийн Жаргалант тосгоны ЗАА	1	1,977.6					1	1,977.6				
Орон нутгийн байгууллагын дүн	21	238,764.6	2	6,289.7	1	0	18	232,474.9	0	0	0	-
СХД-ийн Төхижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ	5	12,791.0					5	12,791.0	-	-	-	-
ОНӨААН-ийн дүн	5	12,791.0	0	-	0	0	5	12,791.0	-	-	-	-
Нийт дүн	27	251,555.6	2	6,289.7	1	0	24	245,265.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СХД-ийн Засаг даргын Тамгын газар	2	252,555.1			1	252,555.1	1	
СХД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	81,938.0			1	60,938.0	2	21,000.0
СХД-ийн Жаргалант тосгоны Соёлын ордон	1	47,069.9					1	47,069.9
Орон нутгийн байгууллагын дүн	6	381,563.0	0	0	2	313,493.1	4	68,069.9
СХД-ийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ	3	672,724.5	1	415.4	2	672,309.1		
СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ	1	-					1	
ОНӨААН-ын дүн	4	672,724.5	1	415.4	2	672,309.1	1	
Нийт дүн	10	1,054,287.5	1	415.4	4	985,802.2	5	68,069.9

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	14	3	11		3			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	15	4	11		4			

